

2021/2022 оны Бага сургуулийн бүртгэл

Энэ хичээлийн жилд сургуулийн заавал эзэмших боловсролын бүртгэл нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн зохицуулалтын дагуу явуулагдана (Сургуулийн тухай хууль, Суурь боловсролын тухай тогтоол ба Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль), өнгөрсөн жилд явж байсан заавал эзэмших боловсролын бүртгэлийн асуудлууд нь өөрчлөгдөөгүй байна. Энэ сургуулийн жилд халдварт өвчний эсрэг арга хэмжээ авахтай холбогдуулан **хүүхэд ба насанд хүрэгчдийн аюулгүй байдлыг хангаж, оролцогчдын хувь хүний боломж ба хязгаарлалтыг хүндэтгэж**, шаардлагатай зохион байгуулалтаа зохицуулж, зэрэгцээгэр нь бүх хууль ёсны үүргээ биелүүлэх болно.

Бүртгэл хийх хугацаа

Сургуулийн тухай хуулиар тогтоосон хугацаанд¹ бүртгэл явагдана, тэгвэл 2021 оны 4-р сарын 1-нээс 4 сарын 30-нд хүртэл хугацаатай байна. Сургуулийн захирал нь энэ тогтоосон хугацааны дагуу сургуульд заавал эзэмших боловсролын бүртгэлийн хугацаа тогтооно, энэ нь Сургуулийн тухай хуулийн дагуу зохицуулагдана.

Бага сургуульд ZŠ a MŠ T. Ježka Ralsko – Kuřivody, Kuřivody 700

бүртгэл дараагийн өдрүүдэд болно 12.4.2021 od 13:30 do 16:00 hodin; 19.4.2021 od 13:30 do 15:00 hodin

Өргөдөл гаргах аргууд

Сургуульд заавал эзэмших боловсролд орох нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн дагуу явуулагддаг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 37-р зүйлд заасны дагуу сургуульд элсэх өргөдлийг бичгээр болон амаар протоколд тэмдэглэж хийдэг эсвэл цахим хэлбэрээр явуулж болдог.

Суурь боловсролд элсэх өргөдлийг сургуулийн вэб-сайтаас олж болно: www.skolakurivody.cz

Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчид нь дараахь аргаар өргөдөл гаргаж болно:

элсэх үед өөрийн биеэр

- сургуулийн мэдээллийн хайрцагт

wxpmihi

- и-мэйлээр, хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн цахим гарын үсэгтэй байх ёстой reditelna@skolakurivody.cz

- шуудангаар (шуудангийн байгууллагад өгсөн огноо шийдвэрлэнэ), өөрийн биеэр сургуульд дараагийн хаягаар ирж өргөдөл гаргаж болно: ZŠ a MŠ T. Ježka Ralsko – Kuřivody, Kuřivody 700, 47122 Ralsko - Kuřivody

Хэрэв хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь дээр дурдсанаас өөр техникийн хэрэгслээр өргөдөл гаргавал (жишээлвэл, и-мэйлээр, гэвч хүлээн зөвшөөрөгдсөн цахим гарын үсэггүйгээр, факсаар гэх мэт), 5 хоногийн дотор энэ өргөдлөө баталгаажуулах шаардлагатай, тэгэхгүй бол ийм өргөдлийг сургууль нь хүлээж авахгүй.

Хууль ёсны төлөөлөгч нь өргөдөлд хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбарыг, дижитал хэлбэрээр (сканнердах, гэрэл зураг) эсвэл цаасан хэлбэрээр – энгийн хуулбар байж болно. Энэ хуулбар нь дараа нь хүүхдийн хавтаст хэргийн бүрэлдэхүүн хэсэг болно.

Нэмэлт мэдээлэл

- **Сургуулийн ирцийг хойшлуулах** тухай өргөдөл гаргахдаа хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь Сургуулийн зөвлөгөө өгдөг байгууллагын зөвлөмж (ŠPZ) ба мэргэжлийн эмчээс авсан эсвэл клиник сэтгэл зүйчийн тодорхойлолтыг авчирдаг. Сургуулийн зөвлөгөө өгдөг байгууллагын үйл ажиллагаа нь хямралын арга хэмжээгээр таслагдаагүй. Сургуулийн зөвлөгөө өгдөг байгууллага нь, заримдаа хязгаардламал хүрээтэй ч гэсэн, цаашдаа ч шаардлагатай үйлчилгээ үзүүлсээр байна, өөрөөр хэлбэл, голцуу сургуульд заавал хамрагдах үүргийг хойшлуулах тухай өргөдлийг шийдэдэг. Хэрэв хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь

сургууль хойшлуулах тухай өргөдөл гаргахдаа холбогдох зөвлөмжийг ирүүлээгүй бол, ийм тохиолдолд бүртгэл хийх тухай захиргааны үйл ажиллагаа нь зогсоогдож, сургуулийн захирал нь шаардагдсан зөвлөмжийг олж авчрах хугацаа тогтоодог. Хэрэв хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь тогтоосон хугацаанд шаардагдсан зөвлөмжийг авчирч нотлохгүй бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 66-р зүйлийн 1-р шинэ мөрийн с) үсэгт заасны дагуу өргөдөл гаргах үйл ажиллагаа нь зогсоогдох болно.

- Хэрэв сургуулийн захирал нь **шаардагдсан баримт бичгүүдийн үнэн зөв гэдэгт эргэлзээтэй** байвал, хууль ёсны төлөөлөгчдөөс баримт бичгийн эх хувь эсвэл баталгаажуулсан хуулбарыг шаардаж болно.

•